



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 4 сарын 9 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Лувсанчүлтэм овогтой Мягмарсүрэн, Даш овогтой Соёл-Эрдэнэ нарыг ОХУ-ын Гадаад хэргийн яамны дэргэдэх Дипломатын академид, Төмөрбаатар овогтой Бат-Өлзийг АНУ-ын Колорадо мужийн Денверийн Их сургуулийн магистрантурт харьцуулсан эрх зүйн чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2003-2004 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Их Британийн Нэгдсэн Вант улсын Кембриджийн Их сургуулийн докторантурт нийгмийн антропологиин чиглэлээр суралцаж буй Дулам овогтой Бум-Очир, тус улсын Шеффельдийн Их сургуулийн докторантурт анагаах ухааны чиглэлээр суралцаж буй Лхагва овогтой Ундрам нарын суралцах хугацааг тус тус нэг жилээр сунгасугай.

3. БНПУ-ын Вроцлав хотын Анагаах ухааны академийн докторантурт суралцаж буй Рэнцэн овогтой Батцэнгэлийн эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

4. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



А.ЦАНЖИД